



ЗӨВШӨӨРӨВ:
ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ
ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

.....Д.ОЧИРБАТ

БАТЛАВ:
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
НҮҮР АМ СУДЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

.....Ч.ГАНТӨМӨР



НҮҮР АМНЫ ИХ ЭМЧИЙН
“НҮҮР АМНЫ ГАЖИЛ ЗАСАЛ СУДЛАЛ”
ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Индекс: S(r) 091103

Хугацаа: 2 жил

УЛААНБААТАР ХОТ
2024 он

БОЛОВСРУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ

Б.Од

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нүүр ам судлалын сургуулийн, Нүүр амны гажиг заслын тэнхимийн ахлах багш, Анагаах ухааны доктор

Г.Ганжаргал

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нүүр ам судлалын сургуулийн, Нүүр амны гажиг заслын тэнхимийн ахлах багш, Анагаах ухааны доктор, дэд профессор

Ж.Цолмон

Тархи судлалын хүрээлэнгийн захирал, Анагаахын шинжлэх ухааны доктор, профессор

ХАМТРАН АЖИЛЛАСАН

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн төлөөлөл:

Д.Одончимэг

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нүүр ам судлалын сургуулийн, Нүүр амны согог, гажиг заслын тэнхимийн ахлах багш, Анагаах ухааны доктор, дэд профессор

Б.Оюунжаргал

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нүүр ам судлалын сургуулийн, Нүүр амны гажиг заслын тэнхимийн дадлагажигч багш, Анагаах ухааны магистр

Б.Оюунцэцэг

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нүүр ам судлалын сургуулийн, Хүүхдийн нүүр ам судлал урьдчилан сэргийлэхийн тэнхимийн ахлах багш, Анагаах ухааны доктор, профессор

Б.Баярчимэг

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нүүр ам судлалын сургуулийн, Шүдний Тулгуур Эд Сувгийн Эмчилгээний тэнхимийн ахлах багш, Анагаах ухааны доктор, дэд профессор

Р.Оюунтөгс

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нүүр ам судлалын төв эмнэлгийн, Нүүр амны гажиг заслын тасгийн дүрс оношилгооны тэргүүлэх зэрэгтэй, клиникийн профессор, Анагаах ухааны магистр

Эрүүл мэндийн байгууллагын төлөөлөл:

М.Эрдэнэсайхан

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хүүхдийн зөвлөх поликлиникийн тасгийн шүдний эмч, нүүр амны гажиг заслын эмч, ахлах зэрэгтэй, клиникийн профессор

ХЯНАСАН:

С.Эрдэнэтуяа

Эрүүл мэндийн яамны Төрийн Захиргааны удирдлагын газрын дарга, Анагаах ухааны доктор

Н.Дашдондов

Эрүүл мэндийн яамны Төрийн Захиргааны удирдлагын газрын Хүний нөөцийн мэргэшил, сургалт, мэргэшлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл асуудал хариуцсан мэргэжилтэн

Д. Дондогмаа

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн хөгжлийн албаны ахлах мэргэжилтэн, Анагаах ухааны магистр

ШҮДНИЙ ИХ ЭМЧИЙН “НҮҮР АМНЫ ГАЖИГ СУДЛАЛ” ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Сүүлийн жилүүдэд хүүхэд болон насанд хүрэгчдийн дунд зажлах эрхтний тогтолцоонд шүд цөөрөх буюу шүдгүйдэл, шүдний тулгуур эдийн өвчин, нүүр амны булчингийн хүчний тэнцвэр алдагдах, эрүүний үений эмгэг зэрэг нь гоо сайхан болоод нийт эрүү нүүрний тогтолцооны өсөлт хөгжилд хямрал үүсгэх шалтгаан болдог байна.

ДЭМБ-ын мэдээллээс үзэхэд (1993) нүүр амны зонхилох эмгэгт шүд цоорох өвчний дараа хүүхдийн шүд ургалтын болон шүд, эрүү нүүрний гажиг орж байна. Энэ төрлийн эмгэгийн тархалт нь 1983 онд хийсэн судалгаагаар Монгол Улсын хэмжээнд 64.66% байсан. Харин 2010-2011 онд 5-18 настай хүүхдийн шүд эрүүний гажгийн тархалтыг судалсан дүнгээс харахад дунджаар 70%, 2020 онд хийсэн судалгаанд 84% хүртэл өссөн байна. Иймээс манай орны хот хөдөөгийн эмнэлгүүдэд нүүр амны гажиг заслын эмчилгээг бие даан явуулах онол, арга зүйн үндсийг эзэмшиж, нүүр амны гажгийн оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх аргуудыг суралцах нь энэхүү хөтөлбөрийн үндэслэл болж байна.

ХОЁР. ЭРХЭМ ЗОРИЛГО

Сургалтыг олон улсын жишгээр зохион байгуулж, олон улсын түвшинд тэнцэхүйц мэдлэг ур чадвартай, эрүүл мэндийн салбарын бүх түвшинд ажиллах хэмжээний мэргэжилтэн бэлтгэхэд оршино. Нүүр амны гажиг заслын резидентийн сургалтад хүн амын дунд тохиолдох шүд ургалтын болон шүд эрүүний гаж хөгжлийг оношлох, зэмсгээр болон дасгалаар засаж эмчлэх, урьдчилан сэргийлэх онолын мэдлэг, дадлага, чадвар, хандлага эзэмшсэн, ёс зүйтэй нүүр амны гажиг заслын мэргэжлийн эмч бэлтгэхэд оршино.

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Эмч хүний мэргэжлийн хариуцлагыг бүрэн ухамсарласан, үйлчлүүлэгчийн эрх, эмчийн ёс зүйг дээдлэн ажилладаг, урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх онолын болон өндөр мэдлэгтэй, эрдэм шинжилгээ, судалгаа, нотолгоонд суурилсан, инноваци бүхий мэргэжлийн ур чадвар эзэмшсэн мэргэжилтэн байна.

ДӨРӨВ. ЦОГЦ ЧАДАМЖ

Чадамж бүхий эмч болохын тулд дараах дэд чадамжийг эзэмших, мэргэжлийн тусламж үйлчилгээг бие даан гүйцэтгэж чаддаг болно. Үүнд:

1. Нүүр амны гажиг заслын эмч байх (*orthodontist*)

2. Мэргэжлийн байх (*professional*)
3. Суралцагч байх (*learner*)
4. Харилцагч байх (*communicator*)
5. Хамтрагч байх (*collaborator*)
6. Эрүүл мэндийн зөвлөгч байх (*community health advocate*)
7. Зохион байгуулагч, манлайлагч байх (*leader*)

ТАВ. СУРГАЛТЫН ЗОРИЛТ

Хөтөлбөр нь доорхи зорилтыг ханган биелүүлнэ:

1. Нүүр амны гажиг заслын эмч байх (*orthodontist*)

- Нүүр амны гажигийн бүтэц, үйл ажиллагааны хямрал, үндсэн бүтцийн өөрчлөлтийг онолын өндөр түвшинд мэдэх;
- Нүүр амны гажигийн үед үүсэх үйл зүйн болон эмнэл зүйн шинжийг судалж, онош тогтоох;
- Нүүр амны гажиг заслын тасагт өвчтөн оношлох, эмчлэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх аргад суралцах;
- Шүд, эрүү нүүрний гажгийг авагддаг болон авагддаггүй зэмсэг эмчилгээ ба тэдгээрийн хавсарсан эмчилгээний зарчим, бэхжүүлэх эмчилгээний ерөнхий зарчимд суралцах;
- Нүүр амны булчингийн дасгал, түүнийг эрүү нүүрний системийг хэвийн хөгжүүлэхэд чиглүүлэх зарчим;
- Биомеханикийн үндсэн зарчимд суралцах;
- Ортогнатик хагалгааны зарчимд суралцах.

2. Мэргэжлийн байх (*professional*)

- Нүүр амны гажиг засал судлалын бусад салбар шинжлэх ухааны өндөр мэдлэгтэй, тухайн эрүүл мэндийн байгууллагад өөрийн мэргэжлээр хувь нэмэр оруулах чин хүсэл эрмэлзэлтэй байх;
- Өвчтөнийг хувь хүний хувьд хүндэтгэж, хамгийн оновчтой зөв шийдвэр гаргахын төлөө ажиллах;
- Өвчтөний түүх, эмнэлгийн бусад баримт бичгийг зөв хөтлөх, бүрдүүлэх, хадгалах, хамгаалах;
- Эмнэлгийн дотоод халдвараас бүрэн хамгаалах ажлын чанарын үзүүлэлтийг гаргаж чаддаг байх;
- Нүүр амны гажиг заслын эмчилгээний менежмент;
- Нүүр амны гажиг заслын клиникийн бүтэц зохион байгуулалт;
- Нүүр амны гажиг заслын эмчийн ажлын байр, тоноглол, түүнийг арчлах, хамгаалах, ажиллуулах зарчим;
- Халдвар хамгаалалын дэглэм, эрүүл ахуйн шаардлага;
- Хөдөлмөр зохион байгуулалт, эргономикийн шинжлэх ухааны үндэс;
- Эм материал зарцуулалт, тооцоо гаргах, орцын норм, түүнийг мөрдөх.

3. Суралцагч байх (*learner*)

- Өөрийн мэдлэг, ур чадвараа сайжруулахын тулд хэрэгцээт сургалтанд байнга хамрагдах;

- Өдөр тутам шинэчлэгдэж байгаа анагаах ухааны дэвшлээс хоцрохгүйн тулд бие даан тасралтгүйгээр суралцах, олон төрлийн мэдээллийн эх үүсвэрийг судлах, дүн шинжилгээ хийх;
- Хамтран суралцагч эмч, эмнэлгийн бусад мэргэжилтэнд заах замаар өөрийн мэдлэг ур чадвараа сайжруулах;
- Шүд эрүүний гажгийн асуудлаар энгийн судалгаа шинжилгээний ажил хийх мэдлэг, ур чадвартай байх.

4. Харилцагч байх (*communicator*)

- Багаар ажиллах өндөр мэдлэг, ур чадвартай байх;
- Анагаах ухааны ёс зүйн мэдлэгтэй байх;
- Өвчтөн болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл садны хүнтэй зүй зохистой үг хэллэг ашиглан зөв боловсон харилцах;
- Өвчтөн шаардлагатай мэдээлэл өгөхдөө ойлгоход хялбар үг хэллэнг ашиглан тайлбарлах;
- Шаардлагатай тохиолдолд өвчтний оношилгоо, эмчилгээний талаар эмнэлгийн бусад мэргэжилтэнтэй зөвлөх.

5. Хамтрагч байх (*collaborator*)

- Тухайн орон нутгийн болон үйлчлэх хүрээний эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой асуудлаар мэргэшлийн эмч нартай мэдээлэл солилцох, хамтран ажиллах;
- Эмнэлгийн бусад тасгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй мэргэшлийн мэдлэг мэдээллээ хуваалцаж хамтран ажиллах.

6. Эрүүл мэндийн зөвлөгч байх (*community health advocate*)

- Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Хүн амд шүд эрүүний гажгаас урьдчилан сэргийлэх (буруу зуршлаас) сургалт сурталчилгаа явуулах, эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөн өрнүүлэх мэдлэг, ур чадвартай байх.

7. Зохион байгуулагч, манлайлагч байх (*leader*)

- Мэргэжлийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохицуулах, манлайлан ажиллах үүргээ ухамсарлах.

ЗУРГАА. СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ

6.1 Сургалтын чиглэл, хугацаа, байршил

- Сургалтын хугацаа 2 жил буюу 88 долоо хоног байна. Сургалтын хугацаанд резидент жилд 1 сар амарна.
- Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн шийдвэрээр “Нүүр амны гажиг засал судлал” үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх зөвшөөрөл олгогдсон эмнэлэг нь энэхүү сургалт явуулах үндсэн байгууллага байна.
- Сургалт явуулах үндсэн байгууллага болон бусад байгууллагын тасаг дээр суралцаж ажиллах хугацаандаа Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж

- үйлчилгээний тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан "Резидент эмчийн ажиллах үлгэрчилсэн журам" болон сургалт эрхлэх байгууллагын дотоод дүрэм, журмын дагаж мөрдөнө.
- Нүүр амны гажиг заслын үндсэн мэргэшлийн сургалтанд хамрагдаж буй бүх резидент эмч нар эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандалага, халдварын сэргийлэлт, хяналт, амилуулах суурь тусламж, Эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль, журам, Зөрчилийн тухай хууль, хувь хүний нууц, хүний эрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх, жендерийн тэгш байдал, Эмнэлгийн эрх зүйн чиглэлээр сургалтанд (orientation) заавал хамрагдсан байна.

6.2 Зайлшгүй таньж мэдэх, суралцах шаардлагатай гажгууд, тэдгээрийн шинж тэмдэг, гардан үйлдэл:

Сургалтын төгсгөлд ажлын байранд ганцаараа бие даан тусламж үйлчилгээ үзүүлж чадах төвшинд хүрэхийн тулд эмнэлзүйн сургагч багшийн хяналтан дор тасгаар үйлчлүүлэгчдийн оношилгоо, эмчилгээ хариуцан хийх явцдаа дараах шинж тэмдэг, гажгууд, гардан үйлдлийг гүйцэтгэж туршлага хуримтлуулсан байна.

6.2.1 Нүүр амны гажгийн шинж тэмдэг

1. Хоншоор, эрүүний нэгдүгээр их араа шүднүүдийн харьцаа алдагдах (Incorrect maxillary and mandibular molars relationship)
2. Хоншоор, эрүүний соёо шүднүүдийн харьцаа алдагдах (Incorrect maxillary and mandibular canine relationship)
3. Үүдэн шүднүүдийн босоо ба дагуу чиглэлийн зөрүү багасах эсвэл ихсэх (Increased or decreased overjet and overbite)
4. Голын шугам зөрөх (Midline deviation)
5. Шүднүүд эргэх (Teeth rotation)
6. Шүдний мезиал, дистал налуу ба уруул ба хэлэн талын налуу өөрчлөгдөх (Changes in tooth inclination and angulation)
7. Зайтай байх (Spacing)
8. Шүдний нуманд бөөгнөрөлтэй байх (Crowding)
9. Нумын хэлбэр өөрчлөгдөх (Changes in arch form)
10. Нүүрний тэгш хэм алдагдах (Facial asymmetry)
11. Нүүрний төрх ба эрүүний өнцөг өөрчлөгдөх (Changes in facial profile and mandibular angle)
12. Нүүрний дээд, дунд, доод 1/3 харьцаа алдагдах (Changes on facial upper, mid and lower 1/3 height (relationship))
13. Эрүүний үений эмгэг үүсэх (Temporomandibular joint disorder)
14. Буруу зуршил (Oral habits)
15. Хоншоор, эрүүний ясны босоо, дагуу, хөндлөн чиглэл дэх харьцаа алдагдах (Changes in vertical, horizontal, and sagittal relationship of maxilla and mandible)
16. Хоншоор, эрүүний шүдний нум хооронд босоо, дагуу, хөндлөн чиглэл дэх харьцаа алдагдах (Changes in vertical, horizontal, and sagittal relationship of the maxillary and mandibular dental arch)

6.2.2 Зайлшгүй суралцаж, таньж мэдэх шаардлагатай гажгийн төрлүүд Шүд, эрүү нүүрний гажиг (Dentofacial anomalies)

1. Тодорхой бус шалтгаант эрүүний хэмжээний гажиг (Unspecified anomaly of jaw size)
– M26.00

2. Хоншоорын хэт томролт (Maxillary hyperplasia) – M26.01
3. Хоншоорын хэмжээ бага байх (Maxillary hypoplasia) – M26.02
4. Эрүүний хэт томролт (Mandibular hyperplasia) – M26.03
5. Эрүүний хэмжээ жижиг байх (Mandibular hypoplasia) – M26.04
6. Ооч урт байх (Macrogenia) – M26.05
7. Ооч жижиг байх (Microgenia) – M26.06
8. Төвгөр ясны хэт томрол (Excessive tuberosity of jaw (entire maxillary tuberosity)) – M26.07
9. Бусад шалтгаант хоншоор, эрүүний хэмжээний гажиг (Other specified anomalies of jaw size) – M26.09

Эрүү, нүүрний үйлийн гажгууд (Dentofacial functional abnormalities)

1. Тодорхой бус шалтгаант, эрүү нүүрний үйлийн гажгууд (Dentofacial functional abnormalities, unspecified) – M26.50
2. Эрүү хэвийн бус хаагдах (Abnormal jaw closure) – M26.51
3. Эрүүний хөдөлгөөн хязгаарлагдах (Limited mandibular range of motion) – M26.52
4. Эрүү хаах ба ангайх үед эрүү хазайх (Deviation in opening and closing mandible) – M26.53
5. Урд хөтөч хангалтгүй байх (Insufficient anterior guidance) – M26.54
6. Төвийн хоршихуй ба голлосон хоршихуйн зөрүү (Centric occlusion maximum intercuspation discrepancy) – M26.55
7. Ажлын бус талын хоршихуйн саад (Non working side interference) – M26.56
8. Араа шүдний тулгуурын дутмагшил (Lack of posterior occlusal support) – M26.57
9. Бусад эрүү, нүүрний үйл зүйн гажиг (Other dentofacial functional abnormalities) – M26.59

Эрүү, чамархайн үений эмгэгүүд (Temporomandibular joint disorders)

1. Тодорхой бус шалтгаант, эрүүний үений эмгэг (Temporomandibular joint disorder, unspecified) – M26.60
2. Эрүүний үений мөгөөрсөн болон ясан анкилоз (бороо) (Adhesions and ankylosis of temporomandibular joint) – M26.61
3. Эрүүний үений үений өвчин (Arthralgia of temporomandibular joint) – M26.62
4. Эрүүний үений үений жийргэвчний эмгэг (Arthralgia of disc disorder of temporomandibular joint) – M26.63
5. Бусад шалтгаант эрүүний үений эмгэг (Other specified disorders of temporomandibular joint) – M26.69

Шүдний нум хоорондын гажиг (Anomalies of dental arch relationship)

1. Тодорхой бус шалтгаант шүдний нум хоорондын гажиг (Unspecified anomaly of dental arch relationship) – M26.210
2. Энглийн I ангиллын гажиг (Malocclusion, Angle's class I) – M26.211
3. Энглийн II ангиллын гажиг (Malocclusion, Angle's class II) – M26.212
4. Энглийн III ангиллын гажиг (Malocclusion, Angle's class III) – M26.213
5. Арааны харьцаа тодорхойгүй гажиг (Malocclusion, Angle's class, unspecified) – M26.219
6. Үүдэн хэсгийн заалхай зуулт (Anterior openbite) – M26.220
7. Араа хэсгийн заалхай зуулт (Posterior openbite) – M26.221
8. Үүдэн шүдний зуултын дагуу зөрүү ихсэх (Overjet) – M26.23

9. Үүдэн ба араа хэсгийн муруй зуулт (Anterior or posterior crossbite) – M26.24
10. Нум хоорондын зайны гажиг (Anomalies of interarch distance) – M26.25
11. Нум хоорондын харьцааны бусад гажгууд, голын шугам зөрөх, үүдэн шүдний зуултын босоо зөрүү ихсэх (Other anomalies of dental arch relationship, midline deviation of dental arch overbite, deep, horizontal, or vertical posterior lingual occlusion of mand. teeth) – M26.29

Шүдний байрлалын гажиг (Anomalies of tooth position)

1. Тодорхой бус шалтгаант, бүрэн шүдэлсэн шүд ба шүднүүдийн байрлалын гажиг (Unspecified anomaly of tooth position of fully erupted tooth or teeth) – M26.30
2. Байнгын зуултын үеийн бөөгнөрөл (Crowding of fully erupted teeth) – M26.31
3. Байнгын зуултын үед хэт зайтай байх (Excessive spacing of fully erupted teeth (diastema)) – M26.32
4. Бүрэн шүдэлсэн шүд ба шүднүүдийн хөндлөн чиглэл дэх байрлалын гажиг (Horizontal displacement of fully erupted tooth or teeth) – M26.33
5. Бүрэн шүдэлсэн шүд ба шүднүүдийн босоо чиглэл дэх байрлалын гажиг (Vertical displacement of fully erupted tooth or teeth) – M26.34
6. Бүрэн шүдэлсэн, эргэсэн шүд ба шүднүүд (Rotation of fully erupted tooth or teeth) – M26.35
7. Байнгын зуултын үед хоншоор, эрүүний хоршилт хангалтгүй, зайтай байх (Insufficient interocclusal distance of fully erupted teeth (ridge)) – M26.36
8. Байнгын зуултын үед хоншоор, эрүүний хэт хоршилттой байх (Excessive interocclusal distance of fully erupted teeth) – M26.37
9. Бүрэн шүдэлсэн шүд ба шүднүүдийн байрлалын бусад гажгууд (Other anomalies of tooth position of fully erupted tooth or teeth) – M26.39

6.2.3 Зайлшгүй хийх гардан үйлдлийн жагсаалт

Эмнэл зүйн тойролт-1 (Нүүр амны гажиг заслын тогтолцоо)	
1	Өвчтөний карт хөтлөх
2	Өвчтөнд зөвлөгөө өгөх
3	Гавлын хажуугийн рентген зураг зурах
4	Гавлын хажуугийн рентген зурагт анатомийн цэгүүдийг байршуулах
5	Гавлын хажуугийн рентген зурагт хэмжилтийн хавтгайнуудыг байршуулах
6	Гавлын хажуугийн рентген зурагт хэмжилт хийх
7	Өвчтөнөөс хэв авах
8	Шүдний эгнээний загвар цутгах
9	Параллель загвар бэлтгэх
10	Шүдний загвар хэмжилт хийх
11	Нүүрний төрхийн фото зураг авах
12	Амны хөндийн фото зураг авах
13	Эрүү нүүрний булчингийн дасгалууд
14	Хоншоор эрүүний шүдний эгнээнээс хэв авах
15	Авсан хэвнээс ажлын загвар цутгах
16	Авсан хэвнээс хяналтын загвар цутгах
17	Авсан хэвнээс оношлогооны загвар цутгах
18	Зуулт болон хоршихуйг лавай хазуулан зуултын өндөр тодорхойлох
19	Хоршилтын цэгүүдийг сонгон өөлөх

Эмнэл зүйн тойролт-2 (Дүрс оношлогоо)	
1	Сурвалжийн оройн зургийг параллелийн болон өнцгийн аргаар авч сурах
2	Сурвалжийн оройн зурагт харагдах эрүүл анатомийн бүтцийг нэрлэж сурах /эмнэл зүйн тохиолдол дээр ажиллана/
3	Дэлгэмэл рентген зураг авч сурах
4	Дэлгэмэл рентген зурагт харагдах эрүүл анатомийн бүтцүүдийг нэрлэж сурах /эмнэл зүйн тохиолдол дээр ажиллана/
5	Хажуугийн телерентген зураг авч сурах
6	Эрүүний үений рентген зураг авч сурах
7	Рентген зураг унших сурах /эмнэл зүйн тохиолдол дээр ажиллана/
Эмнэл зүйн тойролт-3 (Хүүхдийн нүүр амны өвчний урьдчилан сэргийлэлт)	
1	Шүдний өнгөр тодорхойлох
2	Шүдний өнгөр цэвэрлэх
3	Шүд угаалт заах
4	Зөвөлгөө өгөх
Эмнэл зүйн тойролт-4 (Шүдний тулгуур эд)	
1.	Шүдний тулгуур эдийн үзлэг хийх, урьдчилсан онош тавих (Эмгэг хөндийг хэмжих, үнэлэх, Шүдний хөдөлгөөнийг тодорхойлох, үнэлэх, Буйлны байдлыг тодорхойлох, үнэлэх)
2.	Рентген зургаар оношлох (Эрүүл, эмгэг төлөвийг ялгах)
3.	Зөвлөгөө өгөх (Өнгөрөөс урьдчилан сэргийлэх, шалтгааныг тайлбарлаж, эмчилгээний талаар мэдээлэл өгөх)
Эмнэл зүйн тойролт-5 (Шүд эрүүний CI ангиллын гажиг)	
1.	Сүүн зуултын үед шүдний бөөгнөрөлтэй өвчтөнийг оношлох, эмчилгээний төлөвлөгөө боловсруулах, эмчлэх
2.	Холимог зуултын үед шүдний бөөгнөрөлтэй өвчтөнийг оношлох, эмчилгээний төлөвлөгөө боловсруулах, эмчлэх
3.	Байнгын зуултын үед шүдний бөөгнөрөлтэй өвчтөнийг оношлох, эмчилгээний төлөвлөгөө боловсруулах, эмчлэх
4.	0.9 мм ган утас тэгшлэх дасгал
5.	0.7 мм ган утас тэгшлэх
6.	0.9 мм ган утсаар 6 өнцөгт нугалах
7.	0.7мм ган утсаар (U-Loop) нугалах
8.	0.9 мм ган утсаар Proto-type нугалах
9.	0.7 мм ган утсаар (cervical wire) нугалах
10.	0.7 мм ган утсаар Adams-н дэгээ нугалах
11.	0.7мм ган утсаар Labial bow нугалах
12.	0.5, 0.7 мм ган утсаар 3 төрлийн пүрш (тус бүр 5 ш) нугалах
13.	0.9 мм ган утсаар "Canine retractor" нугалах
Эмнэл зүйн тойролт-6 (Шүд эрүүний CII ангиллын гажиг)	
1.	Сүүн зуултын үед орсгой өвчтөнийг оношлох, эмчилгээний төлөвлөгөө боловсруулах, эмчлэх

2.	Холимог зуултын үед орсгой өвчтөнийг оношлох, эмчилгээний төлөвлөгөө боловсруулах, эмчлэх
3.	Байнгын зуултын үед орсгой өвчтөнийг оношлох, эмчилгээний төлөвлөгөө боловсруулах, эмчлэх
4.	Шүдний эгнээг хоёр талруу тэлэх авагддаг зэмсэг
5.	Араа шүдийг арагш түлхэх авагддаг зэмсэг
6.	Шүдний эгнээг нэг талруу тэлэх зэмсэг
7.	Эрүүний шүдний эгнээн дээр хазалтын налуу хавтгайтай (Inclined plane) авагддаг зэмсэг
8.	Хоншоорын шүдний эгнээн дээр хазалтын налуу хавтгайтай (Inclined plane) авагддаг зэмсэг
9.	0.7, 0.9 мм ган утсан дээр гагнуур (Soldering) хийх дасгал
10.	Хоншоорын шүдний эгнээг хоёр тийш тэлэх Quadhelix нугалж гагнуур хийх зэмсэг хийх
11.	Эрүүний шүдний эгнээг хоёр тийш тэлэх Bihelix нугалж гагнуур хийх зэмсэг хийх
12.	Шүдний эгнээнд зай хадгалах (Space maintainer) зэмсэг
13.	Хоншоорын шүдний эгнээн дээр (Transpalatal arch bar) нугалж гагнуур хийх
14.	Хэлэн талын нум (Lip Bumper)
Эмнэл зүйн тойролт-7 (Шүд эрүүний CIII ангиллын гажиг)	
1.	Сүүн зуултын үед шаамий зуултыг оношлох, эмчилгээний төлөвлөгөө боловсруулах, эмчлэх
2.	Холимог зуултын үед шаамий зуултыг оношлох, эмчилгээний төлөвлөгөө боловсруулах, эмчлэх
3.	Байнгын зуултын үед шаамий зуултыг оношлох, эмчилгээний төлөвлөгөө боловсруулах, эмчлэх
4.	Хоншоорын өсөлт дэмжигч зэмсэг (Facial mask)
5.	Үйл зүйн зэмсэг Bionator
6.	Үйл зүйн зэмсэг Twin Block
7.	Эрүүний үений чиг
8.	Авагддаг бэхжүүлэх зэмсэг Hawley
9.	"Френкел I" авагддаг зэмсэг
10.	"Френкел II" авагддаг зэмсэг
11.	"Френкел III" авагддаг зэмсэг
12.	Түлхэгч пүрштэй хуванцар ялтастай авагддаг зэмсэг
13.	Уруулын нумтай хуванцар ялтас
14.	Utility archwire нугалах
15.	"Shoes" loop нугалах
16.	"Wire solder" хийх
Эмнэл зүйн тойролт-8 (Нүүр амны төрөлхийн гажгийн эмчилгээний менежмент)	
1.	Нярайн үеийн уруулын анхдагч мэс заслын өмнөх согог заслын эмчилгээ
2.	Сүүн шүүдний зуултын хожуу үе ба холимог шүдний зуултын эхэн үеийн эмчилгээ
3.	Байнгын шүдний зуултын эхэн үеийн эмчилгээ
4.	Байнгын шүдний зуултын хожуу үе ба ортогнатик мэс заслын эмчилгээ

5.	Ортогнатик мэс заслын үед мэс заслын өмнөх ба дараах эмчилгээний төлөвлөлт
6.	Ортогнатик мэс заслын үед мэс заслын төлөвлөлт (цаасан болон загварын мэс засал)
7.	Мэс заслын явцад хэрэглэх зуултын чигийн зохиомж ба бүтэц

Тойролтын хуваарь

Эмнэлзүйн тойролтууд	Хугацаа	Тойролт хийх эмнэлгүүд
Нүүр амны гажиг заслын тогтолцоо	10 долоо хоног	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нүүр ам судлалын төв эмнэлгийн Нүүр амны гажиг заслын тасаг
Дүрс оношилгоо	2 долоо хоног	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нүүр ам судлалын төв эмнэлгийн Нүүр амны дүрс оношилгооны кабениг
Хүүхдийн нүүр амны өвчний урьдчилан сэргийлэлт	2 долоо хоног	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нүүр ам судлалын төв эмнэлгийн Хүүхдийн нүүр ам судлал урьдчилан сэргийлэлтийн тасаг
Шүдний тулгуур эдийн өвчин	2 долоо хоног	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нүүр ам судлалын төв эмнэлгийн Шүдний тулгуур эд сувгийн эмчилгээний тасаг
Шүд эрүүний CI ангилалын гажиг	22 долоо хоног	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нүүр ам судлалын төв эмнэлгийн Нүүр амны гажиг заслын тасаг
Шүд эрүүний CII ангилалын гажиг	24 долоо хоног	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нүүр ам судлалын төв эмнэлгийн Нүүр амны гажиг заслын тасаг
Шүд эрүүний CIII ангилалын гажиг	24 долоо хоног	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нүүр ам судлалын төв эмнэлгийн Нүүр амны гажиг заслын тасаг
Нүүр амны төрөлхийн гажгуудын гажиг заслын эмчилгээний менежмент	2 долоо хоног	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв Хүүхдийн зөвлөх поликлиник
НИЙТ	88 долоо хоног	

6.3 Тойролтын агуулга

Нүүр амны гажиг заслын тогтолцоо (Эмнэл зүйн тойролт-1)

Зорилт:

Хүн амын дунд тохиолдох шүд эрүү нүүрний гажгийн оношилогоо, эмчилгээг бие даан үзэж, зөвлөгөө өгөх, оношлож эмчлэх, урьдчилан сэргийлэх талаар мэдлэг, чадвар, хандлагатай эмчийн ёс зүйг сахиж төлөвшсөн мэргэжилтэн бэлдэх.

Агуулга:

- Нүүр амны гажиг заслын шинжлэх ухааны үүсэл хөгжил, хөгжлийн үе шат
- Нүүр амны гажиг заслын менежмент
- Нүүр амны гажиг заслын клиникийн бүтэц зохион байгуулалт

- Хүүхдийн эрүү нүүр орчмын эрхтнүүд болон шүдний үүсэл хөгжил, сүүн ба байнгын шүдний анатоми, шүд шүдлэх хөгжих болон зуултын зүй тогтол
- Зуултын хэлбэрүүд, түүнийг үнэлэх, эрүүл зуултын төлвүүд, эмгэг зуултын төлвүүд
- Голлосон хоршилтын араа болон үүдэн бүлэг шүдэн дээрх шинж тэмдгийг үнэлэх, түүний нэршил
- Шүд эрүүний гажигтай хүүхдийн үзлэгийн карт хөтлөх, өвчтөнг шинжлэх аргууд
- Оношилгооны загвар дээр (Moyers, Tanaka & Jonson) нарын аргыг ашиглан загвар дээр хэмжилт хийх
- ДРЗ ба ГХРЗ уншиж, гавлын яс болон хоншоор эрүү ясны цэгүүд хэрчмүүд, хавтгай тодорхойлон хооронд нь харьцуулан дүн шинжилгээ хийх
- Тодорхой шүдний гажгийг оношлох, эмчлэх
- Дагуу, босоо, хөндлөн чиглэлээр үүссэн зуултын гажгуудийг оношлох
- Авагддаг, авагддаггүй зэмсэг эмчилгээний ерөнхий зарчим
- Шүд эрүүний гажгаас урьдчилан сэргийлэх аргууд (буруу зуршил)
- Эрүү нүүрний булчингийн дасгал, түүнийг эрүү нүүрний системийг хэвийн хөгжүүлэхэд чиглүүлэх зарчим
- Эмнэлгийн дотоод халдвараас бүрэн хамгаалах
- Шүд эрүүний гажиг заслын тасагт хэрэглэж буй багаж тоног хэрэгслүүдийг ажиллуулах
- Өвчтөний үзлэгт хэрэглэж дадах, материалын захиалгыг хийж чаддаг, материалын орц нормыг гаргах

Дүрс оношилогоо (Эмнэл зүйн тойролт -2)

Зорилт: Шүд эрүүний гаж хөгжил болон гажгийг эрт оношлох, түүнээс урьдчилан сэргийлэхэд хоншоор эрүүний шүдний эгнээний дэлгэмэл рентген зураг (ДРЗ) болон гавлын хажуугийн, эгц телерентген зургийг унших мэдлэг, чадвар, хандлага олгох, хичээл хоорондын уялдаа холбоог сайжруулах, эмчийн бие даах үйл ажиллагааг хөгжүүлэх, үнэлэх, аргачлалыг боловсронгуй болгох

Агуулга:

- ДРЗураг дээр сүүн шүдний зуултын байдлыг тодорхойлох
- ДРЗураг дээр холимог зуултын байдлыг тодорхойлох
- ДРЗураг дээр байнгын шүдний зуултын байдлыг тодорхойлох
- Эрүүний үений байдлыг тодорхойлох
- ДРЗураг дээр сүүн шүдний сурвалжийн шимэгдэлийг байдлыг тодорхойлох
- ДРЗураг байнгын шүдний эх үүсгэврийн байдлыг тодорхойлох
- Шүдний эгнээнд илүү шүд ургасан байдлыг тодорхойлох
- Нэг шүдний зургийг унших
- Байнгын шүдний эх үүсгэвэр багаа эсэхийг тодорхойлох
- ДРЗургийг шүд эрүүний гажгийг оношлоход
- ТРЗургийг шүд эрүүний гажгийг оношлоход хэрэглэх

Хүүхдийн нүүр амны өвчний урьдчилан сэргийлэлт (Эмнэлзүйн тойролт -3)

Зорилт:

Хүүхэд үеийн шүд цоорох өвчин, шүдний тулгуур эдийн өвчнөөс урьдчилан сэргийлэх, амны хөндийн эрүүл мэндийг сайжруулахад шаардагдах суурь мэдлэг, чадвар, хандлагыг эзэмшинэ.

Агуулга:

- Keyes нарын шүд цоорох өвчнийг үүсгэгч 3 хүчин зүйлс ба шүд цоорох өвчин үүсэх механизм

- Мутанс стрептококк (*Streptococcus mutans*) нянгийн эхээс хүүхдэд дамжих механизм
- Шүд цоорох өвчин ба хооллолтын хамаарал
- Балчир ба сургуулийн өмнөх насны хүүхдэд тохирсон шүд угаах арга
- Цоорлыг хянах
- Шүдний тулгуур эдийн өвчний урьдчилан сэргийлэлт
- Хүүхдийн шүд цоорох өвчин, тулгуур эд, салстын өвчин эмгэгийг урьдчилан сэргийлэх, эмнэл зүйн үйл ажиллагааны үед хүүхдийн сэтгэл зүйг залах, айдасгүй эмчлэх мэдлэг, чадварыг эзэмших

Шүдний тулгуур эдийн (Эмнэлзүйн тойролт -4)

Зорилт:

Шүдний тулгуур эдийн (ШТЭ) бүтэц, үйл зүйн онцлог судлах, шүдний тулгуур эдийн өвчний эмгэг жам, шалтгаан, эмнэл зүй, эмчилгээ, урьдчилан сэргийлэх аргаас суралцах

Агуулга:

- Шүдний тулгуур эдийн бүтэц, үйл ажиллагаа
- ШТЭ-ийн өвчний шалтгаан
- Өнгөрийн бүтэц, найрлага, өнгөр тогтох хүчин зүйлс
- ШТЭ-ийн өвчний эмгэг жам
- Шүдний тулгуур эдийн өвчний урьдчилан сэргийлэлт
- Шүдний тулгуур эдийн өвчтөн шинжлэх, өвчний тавилан
- Буйлны үрэвслийн ангилал, буйлны үрэвслийн эмнэлзүй, ялгах онош, эмчилгээ,
- Шүдний тулгуур эдийн үрэвслийн ангилал, цочмог явцтай шүдний тулгуур эдийн үрэвслийн эмнэлзүй, оношлогоо, ялгах онош
- Шүдний тулгуур эдийн архаг үрэвслийн эмнэлзүй, оношлогоо, ялгах онош
- Шүдний тулгуур эдийн үрэвслийн үед рентгенд илрэх өөрчлөлтүүд
- Шүдний тулгуур эдийн өвчний шалтгааныг арилгах
- Шүдний тулгуур эдийн өвчтөн хяналтанд авах ач холбогдол Зайлшгүй эзэмшвэл зохих чадвар,
- Буйл шүдний эмгэг хөндийг тодорхойлох
- Цус гаралтын зэрэг тодорхойлох
- Шүдний хөдөлгөөн тодорхойлох
- Үүдэвчийн гүн тодорхойлох
- Буйлны хэмжээг тодорхойлох
- Шүдний тулгуур эдийн эрүүл болон зонхилон тохиолдох эмгэг өөрчлөлтүүдийг дүрс оношлогооны аргаар шинжлэх, эмгэг өөрчлөлтийн үед шинжилгээнд илрэх эмгэг шинжүүдийг илрүүлж оношлох, ялган оношлох
- ШТЭ-ийн зонхилон тохиолдох эмгэгийг ялгаж оношлох
- Шүдний тулгуур эдийн зонхилон тохиолдох эмгэгийн шалтгааныг тодорхойлох Зайлшгүй эзэмшвэл зохих хандлага:
- Хүн амын шүдний тулгуур эдийн эрүүл мэндийг хамгаалах ба дэмжих хандлагатай болгох
- Хүн амын дунд шүдний тулгуур эдийн эрүүл мэндийн боловсрол олгох хандлагыг эзэмших
- Шүдний тулгуур эдийн болон гажиг заслын эмчилгээ харилцан нөлөөтэй гэдгийг ойлгож багаар ажиллах чадварт суралцах

Шүд эрүүний CI ангиллын гажиг (Эмнэлзүйн тойролт-5)

Зорилт:

Хүүхэд болон насанд хүрэгсдийн дунд зонхилон тохиолдох шүдний CI ангиллын дагуу, босоо, хөндлөн чиглэлээр үүссэн зуултын гажгийг эрт илрүүлэх, оношлох эмчлэх, урьдчилан сэргийлэх, хянах мэдлэг, чадварыг эзэмшүүлэх

Агуулга:

- Дагуу, босоо, хөндлөн чиглэлээр үүссэн зуултын гажгийн шалтгаан, эмгэг жам, эмнэлзүй
- Өвчтөнөөс хэв аван оношилгооны, ажлын, хяналтын загвар цутгаж үнэлгээ өгөх
- Дэлгэмэл болон гавлын эгц урдаас ба хажуугийн рентген зурагт шинжилгээ хийх
